



23

МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 551

Улаанбаатар

Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр  
суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2010-2011 оны хичээлийн жилээс Сангийн яамны захиалгаар Төмөрхүү Овогтой Мягмарсүрэнг АНУ-ын Бриджпорт их сургуульд Бизнесийн удирдлага, менежментийн чиглэлээр магистрантурт 2 жил, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Цэен-Ойдовын Оюунсайханыг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Индра Гандийн Үндэсний Их сургуульд Боловсрол судлалын чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар докторын сургалтанд Сургалтын төрийн сангийн зээлээр тус тус суралцуулсугай.

2. “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 475 дугаар тушаалын 1 дэх заалтын Гантулгын Энхболортой холбогдох хэсгийн “Хууль зүй, дотоод хэргийн яамны захилгаар” гэснийг “Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захилгаар” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 294 дүгээр тушаалын 1 дэх заалтын Төмөрхүү овогтой Мягмарсүрэнгтэй холбогдох хэсгийг, мөн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 463 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР